



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Монголын ардчилсан хөдөлгөөний намын
даргыг бүртгэж, намын дүрэм /Шинэчилсэн
найруулга/-ийг бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, Э.Золзаяа, Ц.Оч, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Монголын ардчилсан хөдөлгөөний намын дарга болон дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Э.Золзаяагийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын ардчилсан хөдөлгөөний намыг төлөөлж тус намыг үүсгэн байгуулагч Т.Оюунаагаас “Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн Монголын ардчилсан хөдөлгөөний намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх, мөн өөрийн хүсэлтээр намын даргын ажлаас чөлөөлөгдсөн тул шинээр томилогдсон А.Бат-Итгэлтийг намын даргаар бүртгэж өгнө үү” гэсэн өргөдлийг нийт 54 хуудас баримт, 1 ширхэг флаш, 3 ширхэг фото зургийн хамт 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн.

Дээрх өргөдөл, түүнд хавсаргасан баримтуудыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлсэн ба тухайн ажиллагааны явцад нэмэлтээр ирүүлсэн 42 хуудас баримтыг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Монголын ардчилсан хөдөлгөөний намын даргыг бүртгэж, харин бүртгүүлэхээр ирүүлсэн намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийн зарим зүйл, заалт хуулийн шаардлагад нийцээгүй, зөрчилтэй байх тул бүртгэхээс татгалзаж шийдвэрлэлээ.

Монголын ардчилсан хөдөлгөөний намын дүрэм /2008 он/-ийн 7.3.2-т “Намын төлөөллийн төв байгууллага нь 72 төлөөлөгчөөс бүрдсэн Бага хурал байна” гэж заасан байх ба намын Онц их хурлын 2007 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Бага хурлын 33 гишүүнийг баталж, бусад 43 гишүүнийг орон нутгийн зохион байгуулалтаар нөхөн сонгох эрхийг Бага хуралд шилжүүлсэн байна.

Тус намын үүсгэн байгуулагч Т.Оюунаагаас Улсын дээд шүүхэд 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр гаргасан тайлбарт “... Бүгд хурал 76 гишүүнтэй байх ёстой боловч намын санхүүжилтийн асуудлаас шалтгаалан аймаг, нийслэл, дүүргийн нэгж байгуулагдах ажил удааширч, Бүгд хурлын гишүүдийн тоог гүйцээн сонгох асуудлыг хойшлуулсан, 2016, 2024 онд Бүгд хуралд нөхөлт хийсээр өнөөдрийн байдлаар 40 гишүүнтэй” гэжээ. Хэдийгээр намын дүрэмд төлөөллийн төв байгууллагын төлөөлөгчийн тоог 76 байхаар заасан байх боловч бодит байдалд тус тооны төлөөлөгч сонгогдоогүй, намын дүрмийн 9.2, 9.2.8-д “Намын Удирдах зөвлөлийн саналаар намын Их хурлын чөлөөт цагт намын Бага хурлын бүрэлдэхүүнд орон гарвал нөхөн сонгох” бүрэн эрхийн дагуу гишүүдийг төлөөллийн төв байгууллагын шийдвэрээр нөхөн сонгож, 40 гишүүнтэй болсон нь Бүгд хурлын 2016 оны 03, 2024 оны 03 дугаар тогтоол, тэдгээр хуралдааны тэмдэглэлээр тогтоогдож байна.

Монголын ардчилсан хөдөлгөөний намын 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хуралдсан төлөөллийн төв байгууллагын хуралдааны зарыг 40 гишүүнд утсаар мэдэгдсэн болох нь хуралдааны тэмдэглэлд тусгагдаж, уг хуралдаанд нийт 39 гишүүн биечлэн оролцож, ирцийн бүртгэлд гарын үсэг зурсан байх тул хурлын үйл ажиллагаа намын дүрэмд нийцсэн гэж үзэхээр байна.

Улсын дээд шүүхийн 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор бүртгэгдсэн Монголын ардчилсан хөдөлгөөний намын дүрмийн 7.3.2-т “Намын төлөөллийн төв байгууллага нь 76 төлөөлөгчөөс бүрдсэн Бага хурал мөн” гэж заасан байна. Монголын ардчилсан хөдөлгөөний намын төлөөллийн төв байгууллагын хурал 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хуралдахдаа “Бүгд хурал” гэсэн нэршилтэйгээр хуралдсан, тус намаас гаргасан өргөдөлдөө нэмж ирүүлсэн 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 06/26 дугаартай албан бичигт “намын удирдах дээд байгууллага нь Их хурал бол, төлөөллийн төв байгууллага нь Бүгд хурал гэсэн нэр томъёотой байхаар дүрэмд заасан” гэх тайлбар нь бүртгэгдсэн намын дүрмээс зөрүүтэй байгааг дурдах нь зүйтэй. Иймд, намын төлөөллийн төв байгууллагын хурлыг хуралдуулах болон хурлаас гарсан шийдвэрийг Улсын дээд шүүхэд бүртгэгдсэн намын дүрэмд заасан нэр томъёогоор ёсчлох нь зүйтэйг анхаарах шаардлагатай.

Нэг.Намын даргыг сонгосон тухайд:

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна”, 15.2-т “Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана:” гээд 15.2.5-д “намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ”, 17 дугаар зүйлийн 17.6-д “Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага, ... сонгоно” гэж тус тус заажээ.

Монголын ардчилсан хөдөлгөөний намын дүрэм /2008 он/-ийн 9.2-т “Намын бага хурал дор дурдсан бүрэн эрх хэрэгжүүлнэ”, 9.2.5-д “Намын Их хурлын чөлөөт цагт намын дарга, ... орон гарвал намын Удирдах зөвлөлийн саналаар Бага хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхоор нөхөн батлах”-аар заасан байна.

Монголын ардчилсан хөдөлгөөний намын Онц их хурлын 2007 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Т.Оюунаа намын даргаар сонгогдсон хэдий ч Улсын дээд шүүхэд бүртгэлгүй байсан, 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр “...үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болсон тул намын тасралтгүй үйл ажиллагааг хангах үүднээс тус намын даргын үүрэгт ажлаас чөлөөлж өгнө үү” гэх хүсэлтийг гаргасан байх ба Ээлжит IX Бүгд хурлын 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанд хүсэлтээ танилцуулсан болох нь хурлын тэмдэглэлд тусгагдсан байна. Мөн А.Бат-Итгэлт нь 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Бүгд хуралд “хамт олны итгэл хүлээж, намын даргын сонгуульд нэр дэвшүүлж байгаа учир хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү” гэх хүсэлтийг бичгээр гаргасан байна.

2025 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хуралдсан Монголын ардчилсан хөдөлгөөний намын Ээлжит IX Бүгд хуралд оролцвол зохих нийт 40 төлөөлөгчөөс хуралд оролцсон 39 гишүүний 92 хувийн саналаар намын даргаас Т.Оюунааг чөлөөлж, 04 дугаартай тогтоол, санал хураалтад оролцсон 35 гишүүний 97.1 хувийн саналаар А.Бат-Итгэлтийг намын даргаар томилох тухай 05 дугаартай тогтоолыг тус тус баталсан нь Улс төрийн намын тухай хууль /цаашид “Хууль” гэх/ болон Улсын дээд шүүхэд бүртгэлтэй тухайн намын дүрэмд нийцсэн байх тул тус намын даргаар А.Бат-Итгэлтийг бүртгэх нь зүйтэй гэж үзлээ.

Хоёр.Намын дүрэм /Шинэчилсэн найруулга/ хуульд нийцээгүй тухайд:

2.1.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана:”, 15.2.4-т “намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам”, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:”, 17.2.2-т “намын төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгох, эсхүл батламжлах, хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгох, ...” гэж заажээ.

Бүртгүүлэхээр ирүүлсэн намын дүрмийн 10.1-д “Намын Бүгд хурал намын Их хурал, намын хороодын хурлаас дөрвөн жилийн хугацаагаар сонгогдсон 76 гишүүний бүрэлдэхүүнтэй байна”, 10.1.3-т “Аймаг, нийслэлийн, дүүргийн Намын хороо намын Бүгд хурлын нэг, нэг төлөөлөгчийг гишүүдийн хурлаар, улс төрийн шалгуурыг үндэслэж сонгоно”, 10.1.4-т “Аймаг, нийслэлийн, дүүргийн, УИХ-ын олон мандаттай тойрогт намын Удирдах зөвлөлөөс гаргасан удирдамж журмын дагуу Бүгд хурлын бусад гишүүдийг сонгоно”, 10.2-т “Намын Бүгд хурал дор дурдсан бүрэн эрх хэрэгжүүлнэ:”, 10.2.5-д “Намын Их хурлын чөлөөт цагт намын дарга, дэд дарга, намын удирдах зөвлөлийн гишүүд болон ерөнхий нарийн бичгийн дарга нарын орон гарвал намын удирдах зөвлөлийн саналаар Бүгд хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхоор нөхөн батлах”, 11.4-т “Намын Их хурал, аймаг, нийслэлийн Бага

хурлын чөлөөт цагт Хяналтын хорооны гишүүний орон тоо гарвал намын Бага хурал болон аймаг, нийслэлийн намын хороо нөхөн сонгож болно” гэж тус тус заасан байна.

Дүрмийн дээрх заалтаас үзэхэд, Монголын ардчилсан хөдөлгөөний намын төлөөллийн төв байгууллага болох Бүгд хурлын зарим төлөөлөгчдийг Их хурлаас гадна намын хороодын хурлаас сонгохоор, мөн түүнчлэн орон гарвал Бүгд хурлаас нөхөн батлах эрхийг өөртөө олгохоор шийдвэрлэсэн, түүнчлэн намын хяналтын байгууллагын гишүүнийг нөхөн сонгох эрхийг “Бага хурал”-д буюу намын дүрэмд зааснаар аймаг, нийслэлийн намын байгууллагад олгосон нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2-т заасантай нийцэхгүй буюу намын удирдах дээд байгууллагад хадгалагдах онцгой бүрэн эрхийг бусад байгууллагад шилжүүлсэн зөрчилтэй байна.

2.2. Дүрмийн 10.2-т “Намын Бүгд хурал дор дурдсан бүрэн эрх хэрэгжүүлнэ:”, 10.2.7-д “Намын Их хурлын чөлөөт цагт намын мөрийн хөтөлбөр, дүрэмд өөрчлөлт оруулах, журам боловсруулах”, 14.1-д Намын дүрэмд нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг намын төлөөллийн төв байгууллага буюу Бүгд хурал оруулна” гэж тус тус заасан нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” нь намын удирдах дээд байгууллагын онцгой бүрэн эрхэд хадгалагдах хуулийн зохицуулалттай нийцээгүй байна. Хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж заасны дагуу гишүүдийн дийлэнх олонхын саналаар төлөөллийн төв байгууллага намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болох хэдий ч энэ нь намын мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах, намын дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах эрхийг төлөөллийн төв байгууллагад олгоогүй болно.

Мөн дүрмийн 9.3-т “Намын Их хурлын бүрэн эрхэд доорх асуудлууд хамаарна”, 9.3.1-д “... Бага хурлын хуралдаануудаар баталсан дүрмийн өөрчлөлтүүдийг нөхөн ёсчлох” гэж заасан нь намын дүрэмд төлөөллийн төв байгууллагаас оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Их хурлаас батлагдсанаар хүчин төгөлдөр гэж үзэх эсэх нь ойлгомжгүй нөхцөл байдалд хүргэж, хэм хэмжээний хэрэглээний тодорхой бус байдал үүсгэх үр дагавартай байна.

Түүнчлэн дүрмийн 7.3.1-д “... намын төлөөллийн төв байгууллага нь 76 төлөөлөгчөөс бүрдсэн Бүгд хурал мөн”, 16.1-д “Аймаг, нийслэлийн намын Бага хурал нь сум хорооны намын байгууллагаас сонгосон төлөөлөгчөөс бүрдэнэ” гэж зааснаас үзвэл намын төлөөллийн төв байгууллага нь Бүгд хурал, харин аймаг, нийслэлийн намын байгууллага нь Бага хурал гэсэн нэртэй байхаар заажээ. Гэтэл дүрмийн 9.3.1-д “... Бага хурлын хуралдаануудаар ...” гэж аймаг, нийслэлийн намын байгууллага намын дүрэмд өөрчлөлт оруулж, батлахаар тусгасан байгаа нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтыг зөрчсөн гэж үзэхээр байна.

Намын дүрмийн 14.2-т “Намын Бүгд Их хурал намын дүрэмд нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга хийх журмыг тухай бүрд батална” гэсэн намын бүтцийн байгууллагын алиных нь эрх хэмжээ болох нь ойлгомжгүй заалтыг тусгаснаас гадна

дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй этгээд, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх, төслийг хэлэлцэн батлах журам болон намын дүрмийг батлах бүрэн эрхийн хүрээнд түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх нь намын удирдах дээд байгууллагын онцгой бүрэн эрхэд хадгалагдах зохицуулалтыг дүрэмд тусгаагүй байна.

Гурав.Намын дүрэмд зайлшгүй тусгах шаардлагатай зүйлийг орхигдуулсан тухайд:

3.1.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т “намын гишүүнээр элсэх, намын гишүүнээс түдгэлзэх, намын гишүүний эрх, үүрэг, намын гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл”-ийг намын дүрэмд тусгахаар заасан.

Намын дүрмийн 5.1.1-д “намын гишүүн нь төрийн жинхэнэ албан хаагчаар томилогдсон тохиолдолд уг албыг хаах хугацаанд намын гишүүнээс түдгэлзэнэ” гэж намын гишүүн түдгэлзэх үндэслэлийг, 5.1.3-т “Намын гишүүнээс түдгэлзүүлэх болон сэргээхтэй холбоотой шийдвэрийг намын Хяналтын ерөнхий хороо гаргана” гэж заажээ. Харин дүрмийн 5.4.2-т “Сахилгын шийтгэлд сануулах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх шийтгэлийн төрөлтэй байна” гэж заасныг эс тооцвол ямар үндэслэлээр намын гишүүнээс түдгэлзүүлэх, түдгэлзүүлсэн тохиолдолд гишүүнчлэл хэрхэн сэргэх болон түдгэлзүүлэх хугацааг дүрэмд тодорхойлоогүй нь хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан шаардлагыг хангаагүй гэж үзэх үндэслэлтэй байна. Мөн дүрмийн 5.1.3-т заасан “Хяналтын ерөнхий хороо” гэх нэртэй намын бүтцийн байгууллага дүрэмд тусгагдаагүй байх ба дүрмийн 7.5.1-д зааснаар намын хяналтын байгууллага нь Хяналтын хороо байгааг анхаарах шаардлагатай.

Монголын ардчилсан хөдөлгөөний намын дүрмийн 5.4.1-д “Гишүүн нь ёс зүй болон намын дүрэм, хуульд заасан гишүүний үүргээ зөрчсөн, эсвэл Монголын ардчилсан хөдөлгөөний намаас сонгуульд нэр дэвшигчийн эсрэг сурталчилгаанд оролцсон бол сахилгын шийтгэл ногдуулна” гэж сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийг, 5.4.2-т “Сахилгын шийтгэлд сануулах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх шийтгэлийн төрөлтэй байна” гэж сахилгын шийтгэлийн төрлийг тусгасан боловч сахилгын шийтгэлийг намын ямар байгууллагаас ногдуулах, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх журам, мөн сахилгын шийтгэл ногдуулан ямар хугацаанд гишүүний эрхийг түдгэлзүүлэхийг тусгалгүй орхигдуулжээ.

Мөн намын гишүүнийг сахилгын зөрчил гаргасанд тооцож, шийтгэл ногдуулахдаа хөөн хэлэлцэх хугацааны /сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш болон зөрчил гаргаснаас хойш ямар хугацааны дотор тус тус шийтгэл ногдуулах, эсхүл шийтгэл ногдуулснаас хойш ямар хугацаа өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцох/ талаар зохицуулалт алга байна.

3.2.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-т “намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам”-ыг намын дүрэмд тусгахаар заасан байхад Монголын ардчилсан хөдөлгөөний намын дүрэмд зарим зөрчилтэй байдал тогтоогдож байна. Тухайлбал,

3.2.1.Дүрмийн 7.2.1-д “... намын удирдах дээд байгууллага нь тус бүр 10-аас доошгүй гишүүдээ төлөөлсөн 300-500 төлөөлөгчөөс бүрдсэн намын Их хурал мөн” гэж заасан боловч тухайн төлөөлөгчдийг сонгох журам тодорхойгүй. Дүрмийн 9.1-д “... намын ээлжит Их хурлыг дөрвөн жилд нэгээс доошгүй удаа хуралдуулна”, 9.2-т “ээлжит бус Их хурлыг Бүгд хурал зарлаж болно” гэж Их хурлын ээлжит бус хурал хуралдуулах талаар зохицуулсан ч Их хурлын ээлжит хуралдааныг хэн, хэрхэн зарлах, хурлын зарыг төлөөлөгчдөд ямар хугацаанд, хэрхэн мэдэгдэх талаарх зохицуулалт тусгаагүй байна.

3.2.2.Дүрмийн 9.3-т “Намын Их хурлын бүрэн эрхэд доорх асуудлууд хамаарна”, 9.3.1-д “Бага хурал, намын Хяналтын хорооны тайланг хэлэлцэж, Бага хурлын хуралдаануудаар баталсан дүрмийн өөрчлөлтүүдийг нөхөн ёсчлох”, 9.3.2-т “Нам тарах буюу өөр намтай нэгдэх тухай Бага хурлын саналыг хэлэлцэж, шийдвэрлэнэ”, 9.3.3-т “Хууль болон намын дүрэмд заасан бусад бүрэн эрх” гэж заасан нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт зохицуулсан намын удирдах дээд байгууллага өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэх зохицуулалтыг тодорхой тусгаагүй буюу намын төлөөллийн төв болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг сонгох, намын нэрийг өөрчлөх онцгой бүрэн эрхийг дүрмээр зохицуулалгүй орхигдуулсан байна. Мөн дүрмийн 9.3.1, 9.3.2-т “Бага хурал” гэж заасан нь намын төлөөллийн төв байгууллагын нэрийг буруу бичсэн эсэхийг анхаарах шаардлагатай байна.

3.2.3.Дүрмийн 11, 12 дугаар бүлэгт “Хяналтын хороо болон Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам” гэж тус тус заасан ба дүрэмд тэдгээрийн бүрэлдэхүүний тоо, бүрэн эрхийн хугацааны талаарх зохицуулалт байгаа боловч Удирдах зөвлөлийн эрх хэмжээ, гишүүдийг сонгох, чөлөөлөх, огцруулах, нөхөн сонгох журам, хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д заасан санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтныг сонгох зохицуулалтыг, хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасан намын хяналтын байгууллагын маргаан шийдвэрлэх журмыг батлах зохицуулалтыг дүрэмд тусгаагүй нь хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-т заасан шаардлагыг хангасан гэж үзэх боломжгүй байна.

Мөн намын дүрмийн 11.2-т “Хяналтын хороог намын их хурлаас таван гишүүний ... бүрэлдэхүүнтэйгээр дөрвөн жилийн хугацаагаар сонгоно” гэж заасан боловч Хяналтын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх, хэлэлцэх, шийдвэр гаргах журмын талаарх зохицуулалтыг дүрэмд заагаагүй байх ба хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Намын хяналтын байгууллагын гишүүнээр намын төлөөллийн байгууллага болон гүйцэтгэх төв байгууллагын гишүүн, орон тооны ажилтныг сонгохыг хориглоно” гэсэн шаардлагыг тусгаагүй байна.

3.3.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ”-г намын дүрмээр тусгайлан тогтоохоор заасан, үүний дагуу намын даргыг “сонгох”, “чөлөөлөх”, “огцруулах” үндэслэл, шийдвэр гаргах журмыг намын дүрмээр тус тусад нь тодорхой заах шаардлагатай. Тус намын дүрмийн 13 дугаар бүлэгт “Намын дарга, Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ” гэсэн байх боловч тус бүлгийн зохицуулалтад намын даргын бүрэн эрхийн хугацаа,

эрх хэмжээ болон нэр дэвшүүлэх, намын даргыг сонгох журам, огцруулах үндэслэл, хэлэлцэх, шийдвэр гаргах журмыг тодорхой заагаагүй нь хуулийн дээрх шаардлагыг хангахгүй байна.

Түүнчлэн хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д “Намын дарга, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан нь аль нэг аж ахуйн нэгж, байгууллагад санхүүтэй холбогдсон ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно”, 37.11-д “Намын дарга энэ хуулийн 37.9-д зааснаас бусдаар намын санхүү, төсвийн үйл ажиллагаанд захиран зарцуулах эрхтэйгээр оролцохыг хориглоно”, 37.9-д “Намын санхүүгийн тайланг баталгаажуулж намын дарга болон санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан гарын үсэг зурна” гэж заасан хуулийн шаардлагыг намын дүрэмд тусгах шаардлагатайг анхаарах нь зүйтэй.

3.4. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д “намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох арга, журам”-ыг тусгахаар заасан. Намын дүрмийн 22 дугаар бүлэгт “Намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох арга журам” гэж заасан байх боловч 22.1-д “Нам хуульд заасны дагуу бусад үнэт зүйлс нэг намтай нэгдэж болно”, 22.2-т “Нам бусад намтай нэгдэх, үйл ажиллагаа зогсоох шийдвэрийг намын удирдах дээд байгууллага болох Их хурал гаргана”, 22.3-т “Энэхүү үйл ажиллагаа Үндсэн хууль болон Улс төрийн намын тухай хуульд заасан бусад үндэслэл журмыг баримтална” гэснээс үзвэл намыг өөрчлөн байгуулах гэдэгт зөвхөн бусад намтай нэгдэхийг ойлгох эсэх нь тодорхой бус байгаагаас гадна бусад намтай нэгдэх үйл явцад санал гаргах, хэлэлцэн шийдвэрлэх, түүнчлэн намыг өөрчлөн байгуулсан, үйл ажиллагааг нь зогсоосон тохиолдолд үүсэх үр дагаврыг хэрхэн шийдвэрлэх нь дүрэмд тодорхой зохицуулагдаагүй байна.

3.5. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.9-д “Намын хөрөнгө, орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг намын дүрэмд тусгахаар заасан. Намын дүрмийн 20.3-т “Намын бүх шатны байгууллага намын үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор хөрөнгө, хандив хуримтлуулах ажлыг зохион байгуулна” гэж зааснаас өөр намын хөрөнгө, орлогыг бүрдүүлэх зохицуулалт тусгаагүй нь хуулийн 26 дугаар зүйлийн 26.7-д “Нам энэ хуулийн 26.1-д заасан орлогыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр харилцах данстай байхыг хориглоно”, 26.8-д “Нам энэ хуулийн 26.1-д заасан орлогыг цахим мөнгөөр хүлээн авахыг хориглоно” гэж заасан хуулийн шаардлагыг дүрэмд тусгаагүй гэж үзэхээр байна. Намын дүрмийн 20.1-д “намын хөрөнгө нь сонгуульт үүргийн дагуу өгөгдөх гишүүний татвар, хандив, төрөөс олгосон санхүүгийн дэмжлэг, гэрээсэлсэн эд хөрөнгө, намын бэлгэдлийн зүйлс, намын өмчлөлд байгаа барилга байгууламж, намын өөрийн хөрөнгө, намын хэвлэл мэдээлэл, хуульд заасан бусад орлого байна” гэж заасан атлаа хуулийн 34 дүгээр зүйлд заасан хандивтай холбогдуулан намын хүлээх үүрэг, хориглох зүйл, 10 дугаар зүйлийн 10.1.6-д “сонгуульд нэр дэвших эрх олгохдоо намын гишүүн, дэмжигчээсээ барьцаа, дэнчин болон бусад аливаа хэлбэрээр мөнгө болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ өгөхийг шаардах, авах” үйл ажиллагааг нам явуулахыг хориглосон зохицуулалтыг, 32 дугаар зүйлийн 32.6-д заасан намын гишүүний татварыг хөнгөлөх, чөлөөлөх эсэхийг дүрэмд тусгаагүй байгааг дурдах нь зүйтэй.

3.6. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.10-т “намын салбар болон бүтцийн нэгжийг байгуулах, татан буулгах үндэслэл, журам”-ыг намын дүрэмд тусгахаар

хуульчилсан. Намын дүрмийн 7.1.2-т “Аймаг, нийслэл, дүүргийн намын байгууллага байна”, 7.1.3-т “намын анхан шатны байгууллага сум хороонд үүр байна” гэж заасан боловч дүрмийн 7.6-д “намын анхан шатны байгууллагын удирдах байгууллага нь аймаг, нийслэлийн дүүрэгт Бага хурал, сум хороонд бүх гишүүдийн хурал байна” гэсэн нь нийслэлийн намын байгууллагын удирдах байгууллагыг орхигдуулсан эсвэл “нийслэлийн” гэж буруу бичсэн эсэх нь ойлгомжгүй байгааг анхаарах шаардлагатай.

Мөн дүрмийн 7.8-д “намын гүйцэтгэх удирдлага нь намын Удирдах зөвлөл, аймаг, нийслэлийн хувьд намын хороо, анхан шатны байгууллагад түүний даргын зөвлөл хэрэгжүүлнэ” гэсэн нь дүүргийн намын байгууллагын гүйцэтгэх байгууллага нь ямар байгууллага болох, аймаг, нийслэл, дүүргийн намын хороо нь намын ямар шатны байгууллага болох нь тодорхойгүй байна.

Түүнчлэн, намын дүрмийн 8.5-д заасан “намын хурал хуралдуулах, эрх мэдлийн хуваарилалт”-д намын үүрийн болон намын хороодын хурлыг чөлөөт сонголтын болон төлөөлөх сонгуультны хурал гэж ямар шалгуураар ялган тодорхойлох нь ойлгомжгүй, 17.1-д “Намын гишүүдийн тоо, байршлыг харгалзан намын анхан шатны байгууллагыг аймаг, нийслэлийн намын хорооны тогтоолоор байгуулна” гэж заасан ч анхан шатны байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн намын хороог байгуулах үндэслэл, журмыг зохицуулалтгүй орхигдуулсан байна. Намын дүрмийн 16.2-т “Аймаг нийслэл, дүүргийн намын хороод 10-15 гишүүнийг хорооны хурлаараа улс төрийн шалгуурыг үндэслэн сонгоно”, 16.2.1-д “Аймаг, нийслэл, дүүргийн Иргэний Хурлын Төлөөлөгчийн мандаттай уялдуулж, намын дүрэм, Удирдах зөвлөлөөс гаргасан удирдамж, журмын дагуу бусад гишүүдийг сонгоно” гэж зааснаас үзвэл аймаг, нийслэл, дүүргийн намын хороодын гишүүдийн заримыг нь утга, агуулгыг нь дүрэмд тодорхойлон заагаагүй “улс төрийн шалгуур”-аар, бусдыг нь Удирдах зөвлөлөөс гаргасан удирдамжаар сонгохоор заасан нь тухайн шатны намын байгууллагад нийт хэдэн гишүүн сонгох, эдгээр нь ямар шаардлага хангасан байх, сонгуульд хэн санал өгч сонгох болон намын аль байгууллагын шийдвэрээр байгуулагдах нь ойлгомжгүй, хэрэгжих боломжгүй хэм хэмжээг дүрэмд тусгасан байгааг анхаарах шаардлагатай байна.

3.7. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагыг бүрдүүлэхдээ дараах шаардлагыг хангана:”, 8.2.1-д “нууц санал хураалт явуулах;”, 8.2.2-т “гишүүдийн оролцоо, ил тод байдлыг хангах;”, 17 дугаар зүйлийн 17.7-д “Намын төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна” гэснийг намын дүрэмд тусгаагүй орхигдуулсан байна. Дүрмийн 21.2-т “Нэр дэвшүүлэхдээ нууцаар санал хураах, сонгуульт гишүүдийн оролцоог хангах, ил тод байх ...”, 12.3-т “Удирдах зөвлөл нь бүх гишүүдийнхээ зөвлөлөөр шийдвэр гаргана”, 8.2-т “Шийдвэр гаргахдаа нууцаар буюу илээр, эсвэл /зөвшилцөх/ санал нэгдэх зарчмаар шийдвэрлэнэ” гэсэн нь хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан байгууллагыг бүрдүүлэхэд нууц санал хураалт явуулах, 8 дугаар зүйлийн 8.3-т “Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагын болон намын бусад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, цөөнхийн саналыг хэлэлцэх боломж олгож хүндэтгэн үзэх ...” шаардлагыг дүрэмд тодорхой зохицуулсан гэж үзэх боломжгүй.

3.8.Хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т “Намд олгох жил бүрийн төрийн санхүүжилтийн дараах хувийг доор дурдсан зориулалтаар зарцуулна.” гээд 26.3.1-д “төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх”, 26.3.2-т “төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах”, 26.3.3-т “төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэх”, 26.4-т “Энэ хуулийн 26.3.1, 26.3.2, 26.3.3-т заасан зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүйг намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд зарцуулна”, 27 дугаар зүйлийн 27.13-т “Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна” гэж заасан.

Гэтэл намын дүрмийн 20.1-д төрөөс олгосон санхүүгийн дэмжлэг нь намын хөрөнгөд хамаарахаар, 20.4-т “Намын зохих сонгуульт гишүүний татвар, хураамжийн хэмжээ орлогыг хуваарилах, зарцуулах журмыг намын Удирдах зөвлөл тогтоон хэрэгжүүлнэ” гэж заасан нь төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн хэдэн хувийг салбар болон бүтцийн нэгж буюу намын анхан шатны байгууллага болох сум, хорооны намын үүр, аймаг, нийслэл дүүргийн намын хороонд хуваарилах асуудлыг намын дүрэмд нарийвчлан тусгаагүй нь ямар процессын дагуу ямар шалгуур, нөхцөлийг үндэслэл болгон хэдэн хувиар хуваарилах, шийдвэр гаргах эрх хэмжээг хэн, хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

3.9.Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Намын бодлого боловсруулахад зөвлөх, судалгаа хийх, намын гишүүдийг сургаж бэлтгэх, иргэдийн улс төрийн боловсролыг дэмжих үүрэг бүхий бодлогын судалгааны байгууллага намын дэргэд ажиллана”, 19.2-т “Намын бодлогын судалгааны байгууллага сангийн хэлбэртэй байж болох бөгөөд үйл ажиллагаа, санхүүгийн тайланг энэ хуульд заасан журмын дагуу тайлагнах үүрэгтэй” гэж заасан. Үүнээс үзэхэд, намын дэргэд Бодлогын судалгааны байгууллага заавал ажиллах талаар хуульд зохицуулсан байхад тус намын дүрмийн 19.1-д “намын дэргэд сонгогчидтой ажиллах зорилгоор олон нийтийн байгууллагуудыг ажиллуулж болно” гэж зааснаас өөр намын дэргэд ажиллах байгууллагын талаар зохицуулалт тусгаагүй, энэхүү зохицуулалт нь хуульд заасан тодорхой үүргийг хэрэгжүүлэх бодлогын судалгааны байгууллагын талаарх зохицуулалт биш байх тул хуулийн тус шаардлагад нийцээгүй байна.

3.10.Намын дүрмийн 20.4-т “Намын зохих сонгуульт гишүүний татвар, хураамжийн хэмжээ орлогыг хуваарилах, зарцуулах журмыг намын Удирдах зөвлөл тогтоон хэрэгжүүлнэ” гэж заасан нь хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Гишүүний татварын хэмжээ, бүрдүүлэлтийг тухайн намын дүрмээр тогтооно”, 32.2-т “Гишүүний сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиас хэтрэхгүй байна”, 32.3-т “Сонгуульт гишүүний сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй байна”, 32.6-д “Нам өөрийн дүрэм, журмаар намын гишүүний татварыг хөнгөлөх, чөлөөлөхөөр зохицуулж

болно” гэж заасан буюу дүрэмд заавал тусган зохицуулах хуулийн шаардлагыг хангаагүй, дүрмийн зохицуулалт тодорхой биш байна гэж үзэхээр байна.

Учир нь, намын дүрэмд намын гишүүн, сонгуульт гишүүний төлөх сарын татварын хэмжээ хуульд заасан хэмжээгээр эсхүл түүнээс дотогш ямар хэмжээтэй байхыг, гишүүдийн татвар хураамжийг ямар байдлаар /сар эсхүл жилээр гэх мэт/ хураах, татвараас хөнгөлөх, чөлөөлөх тохиолдолд хувь хэмжээ, шалгуур, үндэслэл нь ямар байх, хэрэв хөнгөлж чөлөөлөхгүй бол түүнийгээ дүрэмдээ тусгах зэргээр тодорхойлон заах шаардлагатай. Намын дүрмийн 20.4-т гишүүний татварын талаарх зохицуулалтыг орхигдуулж, зөвхөн сонгуульт гишүүний татвар, хураамжийн хэмжээ, орлогыг хуваарилах, зарцуулах журмыг намын гүйцэтгэх төв байгууллага тогтоохоор заасан нь сонгуульт болон гишүүний аль алиных нь татварыг хуульд нийцүүлэн тодорхой хэмжээг тогтоож, бүрдүүлэх журмыг дүрмээр зохицуулах хуулийн шаардлагыг хангаагүй гэж үзэхээр байна.

3.11. Хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д “Намын санхүүгийн тайланг хянан шалгах нэг, эсхүл түүнээс дээш тооны дотоод аудиторыг намын төлөөллийн төв байгууллагаас дөрвөн жилийн хугацаатай томилно. Түүнийг нэг удаа улируулан томилж болно” гэж заасан. Монголын ардчилсан хөдөлгөөний намын дүрмийн 20.5-д “Намын хөрөнгө орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг Улс төрийн намын тухай хуулийн 26-38 дугаар зүйлүүдэд заасан журмын дагуу тайлагнана” гэж зааснаас өөр намын санхүүгийн тайланг хянан шалгахтай холбоотой зохицуулалт алга байна. Мөн намын дүрэмд төлөөллийн төв байгууллагын бүрэн эрхэд дотоод аудиторыг томилох талаар тусгалгүй орхигдуулснаас гадна аудитор хэрхэн ажиллах талаар дүрэмдээ тодорхойлон заагаагүй байгааг тэмдэглэв.

3.12. Хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Нам энэ хуулийн 39.6-д заасан хугацаанд алдаа, зөрчлөө арилгаж, санхүүгийн тайлангаа шинэчлэн ирүүлээгүй бол сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн /C1 x T1/ хэсгийг дараагийн жилд олгохгүй”, 41.3-т “Энэ хуулийн 41.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн нэгж гаргасан тохиолдолд тухайн асуудлыг нам дүрмээр зохицуулна” гэж тус тус заасан.

Мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5.3-т “энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив хүлээн авснаа мэдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор тухайн хандивлагч болон сонгуулийн төв байгууллагад энэ тухай мэдэгдэж, хандивыг сонгуулийн төв байгууллагад шилжүүлэх”, 34 дүгээр зүйлийн 34.6-д “Нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно:” гэж зааж, мөн зүйлийн 34.6.1-34.6.13-т нэрлэн заасан, 42 дугаар зүйлийн 42.1-д “Нам энэ хуулийн 34.5.3-т заасны дагуу хандивыг шилжүүлээгүй бол тухайн нам хууль бусаар авсан хандивыг хоёр дахин өсгөсөн дүнгээр сонгуулийн төв байгууллагад төлнө. Ийнхүү төлөх шийдвэрийг сонгуулийн төв байгууллага гаргана”, 42.4-т “Энэ хуулийн 42.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн салбар нэгж гаргах тохиолдолд зохицуулах заалтыг нам дүрэмдээ тусгана” гэж тус тус заажээ.

Дээрх хуулийн зохицуулалтаас үзэхэд, сонгуулийн төв байгууллага нь намын санхүүгийн тайланг хүлээн авч хянах бөгөөд алдаа зөрчилтэй тайланг ирүүлсэн нам аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд алдаа зөрчлөө арилгаж, санхүүгийн

тайлангаа шинэчлэн өгөх, ингээгүйн улмаас төрийн санхүүжилтийн тодорхой хэсгийг дараагийн жилд олгохгүй нөхцөл үүссэн, энэхүү алдаа зөрчлийг намын орон нутгийн нэгж гаргасан тохиолдолд хэрхэн шийдвэрлэхийг намын дүрэмд тусгах шаардлагатай. Ийнхүү намын дүрэмд тусгахаар хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэгт тусгайлан заасан зохицуулалтыг тусгаагүй нь буруу байна.

Дөрөв.Бусад асуудлын тухайд:

4.1. Намын дүрмийн 4.3 дугаар зүйлд “4.3.1” дэх заалт байхгүй, 10.2.9 дэх заалтын дараах заалтыг “7.2.10” гэж дугаарласан, дүрмийн 7.5.1-д “... хяналтын байгууллага нь хяналтын хороо байна” гэж заасан байтал 5.1.3-т “...намын Хяналтын ерөнхий хороо” гэж зөрүүтэй нэр томъёо бичсэн, 4.3.4-т “дүртийг”, 15.11, 15.12-т “хуралдаасан”, 15 дугаар бүлгийн гарчигт “хувиарлалт” гэж үг үсгийн алдаатай үг бичигдсэн, мөн 7.3.1-д “... төлөөллийн төв байгууллага нь 76 төлөөлөгчөөс бүрдсэн Бүгд хурал мөн” гэж тодорхойлсон байхад дүрмийн 9.3.5-д “Намын Их хурлыг намын дарга болон Бага хурлаас томилогдсон нэг төлөөлөгч удирдана”, 9.3.8-д “...намын Бага хурлаас намын ээлжит бус Их хурлыг хуралдуулах шийдвэр гаргавал тус намын ээлжит бус Их хурал хуралдаж болно” гэж нэр томъёоны хувьд андуурч бичсэн, 14.2-т “Намын Бүгд Их хурал” гэж заасан нь намын төлөөллийн төв байгууллага эсвэл намын удирдах дээд байгууллагын аль нь болох нь тодорхойгүй алдааг тус тус гаргасан байх тул эдгээрийг засаж ирүүлэх шаардлагатай.

4.2. Намын дүрмийн 4.4.5, 5.3.4, 8.2, 15.14-т заасан зохицуулалтыг Улсын дээд шүүхийн 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 01 дугаартай тогтоолын Тогтоох хэсгийн 2 дахь заалтаар бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байхад тухайн зохицуулалтыг дүрэмдээ тусгасан байгааг анхаарах нь зүйтэй байна.

4.3. Намын дүрмийн 15 дугаар бүлэгт “Намын Их хурлын бүрэлдэхүүний эрх, эрх мэдлийн шилжүүлэлт, хуваарилалт”-ын гэсэн атлаа 15.1-д “Хурлын хуралдааны чөлөөт цагт түүний бүрэн эрхийг тухайн шатны хурлаас сонгогдсон тэргүүлэгчид төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан нь Их хурлаас гадна бусад шатны хурлуудад тус бүлгийн зохицуулалт хамаарч буй эсэх нь тодорхойгүй байна. Мөн тус бүлгийн 15.2-т “... хуралдаан хийх эрх хүчин төгөлдөр байх хугацаа, эрх шилжүүлэх журам ...”, 15.4, 15.5, “... улс төрийн шалгуураар баталгаажсан эрх”, 15.6, 15.7, 15.8, 15.9-д “... таслах эрхтэй оролцогч”, 15.10-т “Улс төрийн шалгуураар баталгаажсан санал”, 15.11, 15.15, 15.16-д заасан зохицуулалтууд нь утга, агуулгын хувьд хуулийн үзэл баримтлалд нийцэж буй эсэхэд анхаарах шаардлагатай байна.

4.4. Дүрмийн 2.2-т намын товчилсон нэрийг “МоАХН” гэж өөрчилсөн байх ба нэрийн энэхүү товчлол нь бичвэр, хэлбэр, авиа дуудлагын хувьд бусад хуулийн этгээдийн товчилсон нэртэй ижил төсөөтэй гэж үзэх, Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт нийцэж буй эсэхийг анхаарах нь зүйтэй.

Иймээс Монголын ардчилсан хөдөлгөөний намын Ээлжит бус IX Бүгд хурлын 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаас баталсан намын дүрэм

/Шинэчилсэн найруулга/-ийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцээгүй үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэв.

Тав. Хугацаа тогтоох талаар:

5.1. Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан хугацаанд буюу 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор намын дүрмийг Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн бүртгүүлэхээр өргөдөл ирүүлсэн боловч хуульд нийцээгүйн улмаас тухайн дүрэм нь бүртгэгдээгүй, буцаагдсан намд алдаа зөрчлөө зассаны үндсэн дээр дахин нэг удаа Улсын дээд шүүхэд хандах эрхийг хугацаа тогтоож олгохоор шийдвэрлэсэн.

5.2. Монголын ардчилсан хөдөлгөөний намын тухайд, дээрх хуульд заасан хугацаанд намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг бүртгүүлэхээр Улсын дээд шүүхэд өргөдөл ирүүлсэн боловч тус намын дүрмийн холбогдох заалтууд нь хуульд нийцээгүй талаар энэ тогтоолын хоёр, гурав, дөрөв дэх хэсэгт дүгнэсэн болно.

5.3. Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд намын дүрмийн зарим заалт хуульд нийцээгүй тохиолдолд зөрчлөө арилгасны дараа дахин хандах, шийдвэрлэх хугацааг тухайлан заагаагүй боловч энэ тохиолдолд Улс төрийн намын тухай хуулийн холбогдох зохицуулалтыг тайлбарлан хэрэглэх үндэслэлтэй гэж үзлээ.

5.4. Тодруулбал, Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т “Улсын дээд шүүх намыг бүртгүүлэх өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичигт дараах зөрчил илэрсэн тохиолдолд ... уг зөрчлийг арилгаж, нэмэлт мэдээллийг ирүүлэх тухай өргөдөл гаргагчид мэдэгдэнэ” гэж заасны дагуу иргэдийн эвлэлдэн нэгдэх үндсэн эрхийг хангах үүднээс хуульд заасан хугацаанд өргөдөл гаргасан намд холбогдох зөрчлөө арилган дахин нэг удаа хандах боломжийг олгох нь зүйтэй.

5.5. Иймд, өргөдөл гаргагчид Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ” гэж зааснаар намын дүрмийн зөрчлийг арилгаж, дахин бүртгүүлэх хугацааг нэг удаа, 60 хүртэл хоногоор олгож байна. Энэ хугацааг өргөдөл гаргагч уг тогтоолыг гардан авснаас хойш тоолж эхэлнэ.

5.6. Тогтоосон хугацаанд зөрчлөө арилгаж, намын дүрмийг бүртгүүлэх өргөдлөө дахин гаргаагүй, эсхүл өргөдөл ирүүлсэн боловч зөрчлөө арилгаагүй бол бүртгэхээс татгалзах бөгөөд ийнхүү татгалзах шийдвэр гарснаар Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлээгүй гэж үзэж, Улсын дээд шүүхэд бүртгэлтэй дүрэм нь уг хугацаанаас бүртгэлгүйд тооцогдох бөгөөд ингэснээр хүчин төгөлдөр байдлаа алдах хууль зүйн үр дагавартай болохыг анхааруулж байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэгт заасныг баримтлан Монголын ардчилсан хөдөлгөөний намын даргаар А.Бат-Итгэлтийг бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэгт заасныг баримтлан Монголын ардчилсан хөдөлгөөний намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг бүртгэхээс татгалзсугай.

3.Энэхүү тогтоолыг гардаж авсан өдрөөс хойш намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт /Шинэчилсэн найруулга/-ийг бүртгүүлэх өргөдлийг 60 хоногийн дотор дахин нэг удаа ирүүлж болохыг мэдэгдсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Э.ЗОЛЗАЯА